

**Петро Матад Лимитэд (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)  
Матад ХХ Талбайн Өрөмдлөгийн Хөтөлбөр**

*ДТ-6 цооногийн өрөмдлөгийг эхлүүлсэн тухай*

Петро Матад (AIM:MATD) нь Монгол Улсын цагаар 2011 оны 06 дугаар сарын 09-ний 14:30 цагт (Британийн Зуны Цагаар 07:30 цагт) Давсан Толгой-6 (“ДТ-6”) хайгуулын цооногийн өрөмдлөгийг эхлүүлсэнийг мэдэгдэхэд таатай байна.

ДТ-6 цооногийг ойролцоогоор 2,100 метрийн үнд хүртэл босоо чиглэлээр өрөмдөх юм. Цооногийн өрөмдлөгийг Компанийн туслан гүйцэтгэгч Ди Кью И Интернэшнл компани гүйцэтгэж байна.

ДТ-6 цооног нь ДТ-1 цооногоос зүүн урд зүгт ойролцоогоор 2.3 км зайд оршдог. ДТ-6 цооногийн геологийн даалгаваруунь хойшоо чиглэлтэй, нарийвчлан тодорхойлогдсон эртний голын өндийн доторхи Дээд Цагаанцав формацийн дээр ялгасан 234 метр зузаан хэсэг (Өгөн Гол) болон түүний доор орших Доод Цагаанцавын формацийн 364 метрийн хэсэг болно.

Өрөмдлөг дууссаны дараа эсвэл тухайн ажлын явцтай уялдуулан дараагийн мэдээллийг хүргэх болно.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай ҮБгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын нүндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км<sup>2</sup> талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км<sup>2</sup> талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед  
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Дуглас Жэй МакГей (Douglas J. McGay)  
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед  
Ричард Бэри/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)

+44 (0)20 7601 6100